

**САНГИЙН ЯАМ**

2020.04.02

**БИЧИГ ХЭРГИЙН МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ  
ҮНИЙН САНАЛ  
АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Тендер шалгаруулалтын дугаар: СЯ/202003045**

Улаанбаатар хот

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**Сангийн яам** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Бичиг хэргийн материал**–ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг **2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 10 цаг 00 минут**-аас өмнө худалдан авах ажиллагааны цахим сайт **www.tender.gov.mn** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 10 цаг 30 минут**-д нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх. Тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Чингэлтэй дүүрэг, С.Данзангийн гудамж,  
Засгийн газрын 2 дугаар байр, “Д” корпус, Сангийн яам,  
713 тоот, Б.Сайнжаргал, 51-267246**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

  - (а) Үнийн санал;
  - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
  - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
  - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
  - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгөөр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

	Гурав. <b>ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ</b>
<b>ТӨӨЗ-ны холбогдох заалт</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
<b>ТӨӨЗ 1.1</b>	<p>Улсын бүртгэлийн гэрчилгээг цахим сайтаас татаж авна. Тендер нээсэн өдрийн байдлаар татварын өр төлбөргүй байх ба тендерийн нээлт хийх өдөр тодорхойлолтыг цахим сайтаас авна.</p> <p>Гүйцэтгэгчээр ажилласан байх туршлага: Сүүлийн 3 жил /2017, 2018, 2019он/ тус бүр ижил, төстэй барааг нийлүүлсэн туршлагатай байх /Гэрээний хуулбараар баталгаажуулна./;</p> <p>Нийт үнэ ирүүлэхээс гадна барааны төрөл тус бүрээр нэгжийн үнийг жагсааж ирүүлнэ.</p> <p>Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд 10 хувийн давуу эрх олгоно. Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлэх тендерт оролцогч давуу эрх эдлэх хүсэлтэй бол энэ тухайгаа нотлоход шаардлагатай баримт, материалыг дотоодын давуу эрхийн зөрүү тооцуулах албан хүсэлтийн хамт ирүүлэх үүрэгтэй.</p> <p>Дотоодын давуу эрхийн зөрүүг тооцоходоо Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл, Сангийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 30-ний өдрийн 58 дугаар тушаалаар батлагдсан “Тендерт оролцогчид давуу эрх олгох аргачлал”-ын дагуу тооцно.”</p>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Цахим тендер тул үнийн саналыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> хаягаар ирүүлнэ.</p> <p>Огноо: <b>2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 00 минут</b></p>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Сангийн яам, С.Данзангийн гудамж, Засгийн газрын 2-р байр, “Д” корпус.</b></p> <p>Огноо: <b>2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 30 минут</b></p>
<b>ТӨӨЗ 2.3</b>	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. <b>[Тендерт оролцогчийг эрх бүхий болохыг нотлохтой холбоотойгоор ТШӨХ-д заасан бүх баримт бичгийг жагсаан бичих]</b></li> <li>2. ...</li> <li>3.</li> </ol>

<b>ТӨӨЗ 6.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багц 1: Бичгийн цаас нийлүүлэх Багц 2: Хэвлэмэл хуудас нийлүүлэх Багц 3: Каноны хор нийлүүлэх Багц 4: Принтерийн хор нийлүүлэх Багц 5: Бичиг хэргийн материал нийлүүлэх Багц 6: Дугтуй нийлүүлэх
-----------------	---

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### 1. Барааны тодорхойлолт:

**Багц-1.** Бичгийн цаас. Double A буюу түүнтэй дүйцэх, 80 гр/м.кв нягтралтай, бүх төрлийн хэвлэгч, хувилагч машинд 1 болон 2 талаар хэвийн ажиллах, удаан хугацааны хадгалалтыг даах;

**Багц-2.** Хэвлэмэл хуудас. Хэвлэмэл хуудасны бичвэр тод, харагдац сайтай байх, цаасан дээр хазайлтгүй, стандартын дагуу зай, хэмжээг тохируулан тэгш хэвлэсэн байх, А4, А5 хэмжээс зөв байх.

**Багц-3.** Каноны хор. Цэнэглэгдээгүй, шинэ хор байх. Хэвлэгч, хувилагч төхөөрөмжид тохирч ажиллах, 1 хороор хэчнээн хуудас хэвлэх үзүүлэлтийг ирүүлэх.

**Багц-4.** Принтерийн хор. Цэнэглэгдээгүй, шинэ хор байх. Хэвлэгч, хувилагч төхөөрөмжид тохирч ажиллах, 1 хороор хэчнээн хуудас хэвлэх үзүүлэлтийг ирүүлэх.

**Багц-5.** Бичиг хэргийн бусад материал. Барааны жагсаалтад дурдсан бичиг хэргийн бусад материал.

**Багц-6.** Дугтуй нийлүүлэх. Дугтуйны хаяг нь стандартын дагуу байх. Дугтуй нь зориулалтын дагуу битүүмжлэх наалттай байна.

Барааг захиалга өгсөн тухай бүрд бараа хүргэх газарт хүргэж өгнө.

- 2. Стандарт:** Нийлүүлэгчийн бүх бараа нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн хандлагыг хангасан байна. Нийлүүлэх бараа нь хүний биед хор хөнөөлгүй, стандартад нийцсэн байх. Барааг захиалагч буюу захиалагчийн төлөөлөгч шалгаж туршина.
- 3. Баглаа, боодол:** Өргөж зөөхөд тохиромжтой байдлаар багцалж бооно.
- 4. Бараа хүргэх газар:** Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, С.Данзангийн гудамж, ЗГ-ын 2-р байр, Д корпус, 5/1
- 5. Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

## БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

### Багц-1: Бичгийн цаас

Нэр	Тодорхой лолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Бичгийн цаас	Бичгийн цаас	1000	Боодол	Сангийн яам	2020.04.14 Захиалгын /жилд 2-3 удаа/	2020.12.31 Захиалгын /жилд 2-3 удаа/	

### Багц-2: Хэвлэмэл хуудас

Нэр	Тодорхой лолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Сангийн яамны албан бланк	A4	11000	ш	Сангийн яам	2020.04.17 Захиалгын /жилд 2-3 удаа/	2020.12.31 Захиалгын /жилд 2-3 удаа/	
Сангийн яамны албан бланк	A5	6500	ш				
Сангийн сайдын албан бланк	A4	4500	ш				
Сангийн сайдын албан бланк	A5	2800	ш				
Сангийн яамны гадаад албан бланк	A4	700	ш				
Сангийн сайдын гадаад албан бланк	A4	700	ш				
Сангийн сайдын тушаалын бланк	A4	700	ш				
Төрийн нарийн бичгийн даргын тушаалын бланк	A4	1400	ш				

### Багц-3: Каноны хор

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
	7220 Black	4	ш	Сангийн яам	2020.04.17 Захиалгын дагуу тухай бүр	2020.12.31 Захиалгын дагуу тухай бүр	
	7220 Y.M.C	6	ш				
	5845 хор	1	ш				
	5945 хор	1	ш				

**Багц-4: Принтерийн хор**

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Принтерийн хор	227 fdw 30a хор	13	ш	Сангийн яам	2020.04.17 Захиалгын дагуу тухай бүр /7 хоногт 1-3 удаа/	2020.12.31 Захиалгын дагуу тухай бүр /7 хоногт 1-3 удаа/	
	2520 хор	1	ш				
	78 A хор	4	ш				
	Hp 1102 хор	1	ш				
	Hp 12 A	10	ш				
	Hp 126 A	1	ш				
	Hp 1536 хор	3	ш				
	HP 3015	1	ш				
	Hp 3050 хор	1	ш				
	Hp 30 A хор	20	ш				
	Hp 55 A	1	ш				
	Hp 78 A хор	6	ш				
	Hp 79 A хор	6	ш				
	Hp 80 A хор	4	ш				
	Hp1015 хор	2	ш				
	Hp1536 хор	3	ш				
	Lbp 2900 хор	2	ш				
	NPG 51 /2520/ хор/	15	ш				
Хор 2050 hp	1	ш					
Хор 3015	1	ш					

**Багц-5: Бичиг хэргийн бусад материал**

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
	Балын харандаа	25	ш	Сангийн яам	2020.04.17 Захиалгын дагуу тухай бүр /7 хоногт 2-3 удаа/	2020.12.31 Захиалгын дагуу тухай бүр /7 хоногт 2-3 удаа/	
	Архив утас	78	ш				
	Архив хавтас	500	ш				
	Дугаарлагч	9	ш				
	Гар мауз	38	ш				
	Хар хавчаар	4	ш				
	Хавчаар өнгийн	33	ш				
	Уртасгагч	20	ш				
	Скоч том	18	ш				
	Үдээсний машин	15	ш				
	Үдээс	60	ш				
	40 хуудастай хавтас	35	ш				
	Корон хавтас	300	ш				
	Цавуу	145	ш				
	Тамганы тос	13	ш				
	Үзгэн бал хар /1.0/	100	ш				
	Үзгэн бал хар	25	ш				

**Багц-6: Дугтуй**

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
	Сангийн яам А4	5750	ш	Сангийн яам	2020.04.17 Захиалгын дагуу тухай бүр /Жилд 2-3 удаа/	2020.12.31 Захиалгын дагуу тухай бүр /Жилд 2-3 удаа/	
	Сангийн яам А5	6250	ш				
	Сангийн яамны гадаад дугтуй А4	675	ш				

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |       |  |
|---|-------|--|
| <b>1. Шалгах болон турших</b>                             | 1.1.  | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b> | 2.1.  | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| <b>3. Оюуны өмчийн эрх</b>                                | 3.1.  | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| <b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>     | 4.1.  | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| <b>5. Баталгаат засварын хугацаа</b>                      | 5.1.  | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>1</b> жил байна.   |
| <b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>                        | 6.1.  | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| <b>7. Төлбөр</b>  | 7.1.  | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>3</b> хоногийн дотор шуурхай хийнэ.   |
| <b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>                         | 8.1.  | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| <b>9. Алданги оногдуулах</b>                              | 9.1.  | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| <b>10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах</b>         | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.  |
| <b>11. Маргааныг шийдвэрлэх</b>                           | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b> | <p>1.1. Бараа хүлээн авах эцсийн цэгт барааг ашиглаж шалгаж туршина. Нийлүүлсэн бараа нь гэмтэлтэй, ашиглах явцад шаардлага хангаагүй бараа нийлүүлсэн тохиолдолд барааг буцаах эсхүл гэрээг цуцална.</p> <p>1.2. Бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу тухайн багцаас хамаарч хүргэлтийг хийх шаардлагатай ба заасан хугацаанд хүргэлтийг удаа дараа хийгээгүй тохиолдолд гэрээг цуцална.</p> |
| <b>4. Баталгаат засвар (ГЕН-5)</b>      | <p>6.1. Баталгаат засварын тусгай шаардлага.</p> <p>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]</p>   |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>              | <p>8.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Барааг хүлээн авсан гүйцэтгэлээр нэхэмжлэхийн дагуу гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p>  |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)</b>  | <p>10.1. Алданги оногдуулах хувь: <b>0.5</b></p> <p>Алдангийн нийт дүн: <b>5</b></p>   |

**ЗАХИАЛАГЧ**

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>2</sup>;  
Үнийн санал;

<sup>1</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>2</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]